

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
3.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
3.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДЭЭД БОЛОВСРОЛЫН
ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Б.МӨНХЗУЛ
ТАНАА

2020.04.01 № 06/398
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй дүгнэлт

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төслийн зохицуулагч Б.Мөнхзул Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 9 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Н.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 025 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2011 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр Дээд боловсролын шинэчлэлийн төсөл хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан. Төслийг хэрэгжүүлэхэд Азийн хөгжлийн банкны энгийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээлээр 12.5 сая зээлжих тусгай эрхийн хөнгөлөлттэй зээл, Монгол улсын Засгийн газар 10 хувийг тус тус санхүүжүүлнэ.

Төслийн удирдах хороо 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хуралдан төсөл хэрэгжих хугацааг 18 сараар сунгах шийдвэрийг гаргаж Сангийн яаманд төслийн хэрэгжих САГ-2020/40/СТА-ТХН

хугацааг сунгуулах хүсэлтийг 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр, дахин 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр тавьж, улмаар Сангийн яам Азийн хөгжлийн банканд 2018 оны 2 дугаар сарын 9-ний өдөр төслийг сунгах албан хүсэлт явуулсан. Азийн хөгжлийн банкнаас Зээлийн хугацааг сунгасан албан бичгийг Сангийн яаманд 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр ирүүлсэн. Төсөл дуусах хугацааг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нийт 18 сараар сунгасан.

Төслийн үйл ажиллагаа 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусч байгаа тул 2019 онд эхлүүлсэн ажлуудыг дуусгах, санхүүжилтийг гаргах ажлууд хийгдэж, зээлийн гэрээний хэрэгжилт 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр дуусвар болно.

Төслийн зорилго:

Төслийн зорилго нь Монгол Улсын их дээд сургууль төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхүйц, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай болоход нь ахиц гаргахад оршино.

Төслийн зорилт:

1. Дээд боловсролын чанар, нийцэл сайжирна.
2. Дээд боловсролын засаглал, удирдлага, санхүүжилтийн үр өгөөж нэмэгдэнэ.
3. Дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдал дээшилнэ.

Төслийн үйл ажиллагаа:

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг сайжруулахын тулд хөтөлбөрийн дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлийг нийт 37 хөтөлбөрт хэрэгжүүлэх, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, төгсөгчдийн мөшгих судалгааг дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдөд хийх, сургууль-үйлдвэрлэлийн түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагуудтай түншлэх, судалгааны чадавхийг бэхжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх, их, дээд сургуулиудын сургалтын орчныг сайжруулах, инженер, технологийн 3 хөтөлбөрт CDIO стандартыг хэрэгжүүлэх ажлуудыг хэрэгжүүлсэн.

Дээд боловсролын засаглал, удирдлага, санхүүжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд төрийн өмчийн 2, хувийн хэвшлийн 2 дээд боловсролын сургалтын байгууллагад засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлэх, их, дээд сургуулийн засаглал, удирдлага, санхүүжилтийн чадавхийг бэхжүүлэх ажлуудыг зохион байгуулсан.

Дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд зайн сургалтын 5 төвийг байгуулж, орон нутгийн багш оюутанд хүрсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дээд боловсролын салбарын гүйцэтгэлийг хянах, нийгмийн болон жендэрийн өгөгдлийг цуглуулах удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх ажлуудыг хэрэгжүүлээд байна.

Төслийн явц 2019 оны эцсийн байдлаар төслийн нийт хэрэгжилт 96.0 хувьтай байна. Үүнд:

- Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн чанар, нийцэмжийг сайжруулах ажлын биелэлт 100.0 хувь,
- Дээд боловсролын засаглал, удирдлага, санхүүжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлын биелэлт 91.0 хувь
- Дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх ажлын биелэлт 87.0 хувь байна.

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дээд боловсролын шинэчлэлийн төсөл Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дээд боловсролын шинэчлэлийн төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Axplorer v.3.0” программ хангамж ашигладаг байна.

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дээд боловсролын шинэчлэлийн төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг сонгож, эрсдэлийн түвшнийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,243,780.9 мянган төгрөгөөс тооцон 42,437.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 64,313.1 мянган төгрөгөөр тооцсон 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 215,425.4 мянган төгрөгөөр буюу 7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,824,184.9	3,069,795.1	245,610.2
Урьдчилж төлсөн зардал	8,650.6	-	(8,650.6)
Үндсэн хөрөнгө	26,665.5	11,290.9	(15,374.6)
Биет бус хөрөнгө	6,159.6	-	(6,159.6)
Нийт хөрөнгө	2,865,660.6	3,081,086.0	215,425.4
Богино хугацаат өр төлбөр	-	2,994.4	2,994.4
Засгийн газрын хувь оролцоо	127,969.2	-	(127,969.2)
Хуримтлагдсан үр дүн	2,737,691.4	3,078,091.6	340,400.2
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,865,660.6	3,081,086.0	215,425.4

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, засгийн газрын хувь оролцооны дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 245,610.2 мянган төгрөгөөр өссөн нь АХБ-аас өмнөх оны зээлийн санхүүжилтийн нөхөн дүүргэлт он дамжиж орж ирсэнтэй холбоотой байна.

Урьдчилж төлөгдсөн дансны үлдэгдэл 8,650.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд урьдчилгаа төлбөр төлсөн бараа ажил үйлчилгээг хүлээн авч зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 15,374.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаар хуримтлагдсан элэгдлийн дүн өссөнөөс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өссөн нь нэр данс зөрүүтэй шалтгаанаар буцаж орж ирсэн 2,994.4 мянган төгрөгөөс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл буурсан нь төсөл анх нээгдэхэд тоног төхөөрөмж худалдан авсан санхүүжилтийг өмнөх үеийн үр дүнд залруулан тайлагнасанатай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Орлогын гүйцэтгэл

/мянган төгрөг/

Санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төсвийн урсгал санхүүжилт	564,700.0	564,700.0	-	100.0
Зээлийн санхүүжилт	6,315,075.6	5,983,358.0	331,717.6	94.7
Хүүгийн орлого	-	39,503.9	-	-
Нийт дүн	6,879,775.6	6,587,561.9	331,717.6	95.8

Тайлант онд төслийн банкны харилцах тусгай болон дэд дансанд байрших мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 39,503.9 мянган төгрөгийн хүүгийн орлого орж, улсын төсөвт 33,071.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт 6,879,775.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,589,775.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,290,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ. Гүйцэтгэлээр зээлийн санхүүжилтийн орлого 5,765,653.4 мянга, улсын төсвөөс 564,700.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 9,427.0 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого олж, нийт 6,339,780.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 4,772,859.1 мянга, хөрөнгийн зардалд 1,256,614.1 мянган төгрөгийг зарцуулж 122,589.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт зардлын 564,700.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6,315,075.6 мянган төгрөгийг АХБ-ны санхүүжилттэй зээлийн гэрээний дагуу санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Урсгал зардалд 5,589,775.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 4,772,859.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Урсгал зардлын гүйцэтгэл 816,916.5 мянган төгрөгөөр хэмнэсэн буюу 85.4 хувьтай байна. Энэ нь зөвлөх үйлчилгээний хэрэгжээгүй гүйцэтгэлийн үлдэгдэл төлбөр 294,065.8 мянган төгрөг, тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Холимог сургалтын агуулга боловсруулах, сургалт явуулах тэтгэлэгт төслийн гүйцэтгэгчийг шалгаруулахаар зарласан сонгон шалгаруулалт цуцлагдсанаар 489,770.1 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 5 эрсдэл тогтоож, нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 150,593.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 144,161.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,432.6 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант онд төслийн Төрийн банканд байршиж байгаа ам долларын тусгай болон дэд дансны харилцах дансанд төвлөрүүлсэн хүүгийн орлого 39,503.9 мянган төгрөг, үүнээс төсөвт 33,071.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, 6,432.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмын 9 дүгээр зүйл, 9.1.11 “гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол төслийн тусгай болон дэд дансны хүүгийн орлогыг захиран зарцуулах, шийдвэр гаргах” гэсэн заалттай нийцээгүй, эрх үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

2. Оюутны тэтгэлгийн 2,994.4 мянган төгрөг нэр данс зөрүүтэй шалтгаанаар буцаж орж ирснийг бусад орлогоор тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалттай нийцээгүй, ангилал ба тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

3. Мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад хүүгийн орлого болон төсөвт төвлөрүүлсэн хүүгийн орлогын дүнг 4,438.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцээгүй, үнэн зөв ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

4. Өмнөх оны урьдчилгаа төлбөр 8,650.6 мянган төгрөгийг тайлант онд гэрээний гүйцэтгэлээр тооцож, зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалттай нийцээгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

5. Санхүүгийн үр дүнгийн тайланд Засгийн газрын НӨАТ-ын чөлөөлөлтийн 128,077.6 мянган төгрөгийн санхүүжилтийг тайлагнаагүй.

Энэ нь Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 2.7.в-д "Засгийн газрын санхүүжилтэд гадаад зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдэж байгаа бараа, материал, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гааль болон НӨАТ-ын татвараас чөлөөлөгдсөн дүнг оруулна" гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон байх болон эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Хүний нөөцийн чадавхи бэхжүүлэх, Өрсөлдөөнт тэтгэлэг, Хөтөлбөр боловсруулах ба хэрэгжүүлэхэд туслалцаа гэсэн ангиллын зардлуудын анхан шатны бүртгэлийг доллар төгрөгөөр, төлөвлөгөө гүйцэтгэлийн хэрэгжилтийг үнэн зөв бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгасныг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 51 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 асуудалд зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидалд зөвлөмж өгөхөөр асуудал гаргаагүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	2,824,184,980.99	3,069,795,095.25
Төгрөгийн харилцах данс	411,568,765.50	352,747,040.75
Төрийн сангийн харилцах данс	411,568,765.50	352,747,040.75
Валютын харилцах данс	2,412,616,215.49	2,717,048,054.50
Валютын харилцах тусгай данс	2,258,633,353.28	2,613,719,194.37
Валютын харилцах дэд данс	153,982,862.21	103,328,860.13
УРЬДЧИЛГАА	8,650,600.00	-
Урьдчилж төлсөн тооцоо	8,650,600.00	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,832,835,580.99	3,069,795,095.25
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
Биет хөрөнгө	26,665,479.81	11,290,929.13
Авто-тээврийн хэрэгсэл	77,646,950.00	77,646,950.00
Хуримтлагдсан элэгдэл	(65,137,163.42)	(72,901,858.42)
Машин, тоног төхөөрөмж	68,357,973.36	68,357,973.36
Хуримтлагдсан элэгдэл	(56,811,555.39)	(64,048,350.46)
Тавилга, аж ахуйн эд хогшил	27,030,768.19	27,030,768.19
Хуримтлагдсан элэгдэл	(24,421,492.93)	(24,794,553.54)
Биет бус хөрөнгө	6,159,600.00	-
Програм хангамж	8,263,530.00	8,263,530.00
Хуримтлагдсан элэгдэл	(2,103,930.00)	(8,263,530.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	32,825,079.81	11,290,929.13
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,865,660,660.80	3,081,086,024.38
Богино хугацаат өр төлбөр	-	2,994,420.00
Ажиллагчидтай холбоотой өглөг		
Бараа ажил үйлчилгээний зардлын өглөг	-	2,994,420.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	2,994,420.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	2,994,420.00
ЭЗНИЙ ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	127,969,233.55	-
Хуримтлагдсан үр дүн	2,737,691,427.25	3,078,091,604.38
Өмнөх үеийн үр дүн	2,026,235,669.22	2,865,660,660.80
Тайлант үеийн үр дүн	711,455,758.03	212,430,943.58
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,865,660,660.80	3,078,091,604.38
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,865,660,660.80	3,081,086,024.38

3.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Татаас санхүүжилтийн орлого	4,845,227,462.06	6,676,135,669.28
Төсвийн урсгал санхүүжилт	322,749,400.00	564,700,000.00
Засгийн газрын бусад орлого	-	128,077,693.70
Зээлийн санхүүжилтийн орлого	4,522,478,062.06	5,765,653,436.88
Зээлийн шууд санхүүжилтийн орлого	-	217,704,538.70
Бараа ажил үйлчилгээний орлого	28,377,192.77	42,003,871.24
Хүүгийн орлого	28,077,192.77	39,503,871.24
Бусад орлого	300,000.00	2,500,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,873,604,654.83	6,718,139,540.52
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
Ажиллагчидтай холбоотой зардал	339,993,777.89	430,023,516.63
Цалин	304,700,755.52	383,308,345.45
Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,293,022.37	46,715,171.18
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,072,000.00	33,072,000.00
Байрны түрээс	33,072,000.00	33,072,000.00
Бусад бараа үйлчилгээний зардал	3,054,378,954.98	4,551,502,254.39
Бичиг хэрэг	2,973,020.79	2,983,545.44
Тээвэр, шатахуун	16,875,212.81	8,816,110.46
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,578,856.72	2,439,668.20
Хангамжийн материал	-	2,273,400.00
Дотоод томилолтын зардал	1,870,400.00	5,324,250.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг зардал	2,542,924,644.20	1,000,607,322.01
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	716,726.28	3,339,530.29
Бараа үйлчилгээний бусад зардал	146,249,739.68	3,283,979,738.61
Тендерийн зардал	-	2,500,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,151,010.76	21,534,150.68
Зээлийн үйлчилгээний төлбөр	323,039,343.74	217,704,538.70
Урсгал шилжүүлэг	113,672,673.95	283,738,815.80
Төсөвт төвлөрүүлэх орлого	113,672,673.95	33,071,276.62
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	122,589,845.48
Татварын чөлөөлөлт	-	128,077,693.70
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	816,336,264.09	1,265,264,703.18
Барилга байгууламж, их засвар	-	67,877,710.91
Тоног төхөөрөмж	816,336,264.09	1,127,659,719.55
Бусад хөрөнгө	-	69,727,272.72
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	4,357,453,670.91	6,563,601,290.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	516,150,983.92	154,538,250.52
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	195,304,774.12	57,892,693.06
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	195,304,774.12	57,892,693.06
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	711,455,758.04	212,430,943.58

3.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
Татаас санхүүжилтийн орлого	4,845,227,462.06	6,548,057,975.58
Зээлийн санхүүжилтийн орлого	4,522,478,062.06	5,983,357,975.58
Төсвийн урсгал санхүүжилт	322,749,400.00	564,700,000.00
Бараа, ажил үйлчилгээний орлого	28,377,192.77	44,998,291.24
Хүүгийн орлого	28,077,192.77	39,503,871.24
Бусад орлого	300,000.00	2,500,000.00
Нэр данс зөрүүний орлого	-	2,994,420.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,873,604,654.83	6,593,056,266.82
Ажиллагчидтай холбоотой зардал	339,993,777.89	430,023,516.63
Цалин	304,700,755.52	383,308,345.45
Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,293,022.37	46,715,171.18
Тогтмол зардал	33,072,000.00	33,072,000.00
Байрны түрээс	33,072,000.00	33,072,000.00
Хангамж, бараа материалын зардал	8,016,107.50	16,512,724.10
Бичиг хэрэг	1,554,400.78	2,983,545.44
Тээвэр, шатахуун	3,882,850.00	8,816,110.46
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,578,856.72	2,439,668.20
Хангамжийн зүйлс	-	2,273,400.00
Томилолт, зочны зардал	2,451,600.00	5,324,250.00
Дотоод албан томилолт	2,451,600.00	5,324,250.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,848,566,354.83	1,003,946,852.30
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,848,566,354.83	1,003,946,852.30
Бараа үйлчилгээний бусад зардал	481,597,620.85	3,439,640,860.71
Бараа үйлчилгээний бусад зардал	44,585,613.16	3,283,979,738.61
Төвлөрүүлэх шилжүүлэг	113,672,673.95	155,661,122.10
Тендерийн зардал	299,990.00	2,500,000.00
Зээлийн үйлчилгээний төлбөр	323,039,343.74	217,704,538.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	3,713,697,461.07	5,148,724,742.44
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	1,159,907,193.76	1,444,331,524.38
Барилга байгууламж, их засвар	-	67,877,710.91
Тоног төхөөрөмж	704,812,853.84	1,119,009,119.55
Бусад хөрөнгө	-	69,727,272.72
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(704,812,853.84)	(1,256,614,103.18)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	195,604,774.12	57,892,693.06
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	195,604,774.12	57,892,693.06
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	650,699,114.04	245,610,114.26
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,173,485,866.95	2,824,184,980.99
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,824,184,980.99	3,069,795,095.25

3.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	127,969,233.55	2,026,235,669.22	2,154,204,902.77
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-
3	Тайлант үеийн үр дүн		711,455,758.03	711,455,758.03
4	2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	127,969,233.55	2,737,691,427.25	2,865,660,660.80
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(127,969,233.55)	127,969,233.55	
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,865,660,660.80	2,865,660,660.80
7	Хөрөнгийн үнэлгээний өсөлт, бууралт			-
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		212,430,943.58	212,430,943.58
9	2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	-	3,078,091,604.38	3,078,091,604.38

3.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-			
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,879,775,600.00	6,029,473,184.82	850,302,415.18	87.6
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	5,589,775,600.00	4,772,859,081.64	816,916,518.36	85.4
4	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,589,775,600.00	4,772,859,081.64	816,916,518.36	85.4
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,304,800.00	46,715,171.18	1,589,628.82	96.7
6	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	48,304,800.00	46,715,171.18	1,589,628.82	96.7
7	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,000,000.00	33,072,000.00	8,928,000.00	78.7
8	Түрээсийн зардал	42,000,000.00	33,072,000.00	8,928,000.00	78.7
9	Хангамж, бараа материалын зардал	37,200,000.00	16,512,724.10	20,687,275.90	44.4
10	Бичиг хэргийн зардал	6,600,000.00	2,983,545.44	3,616,454.56	45.2
11	Тээвэр, шатахууны зардал	21,000,000.00	8,816,110.46	12,183,889.54	42.0
12	Шуудан холбооны зардал	3,600,000.00	2,439,668.20	1,160,331.80	67.8
13	Хангамжийн зардал	6,000,000.00	2,273,400.00	3,726,600.00	37.9
14	Томилолт зочны зардал	7,200,000.00	5,324,250.00	1,875,750.00	73.9
15	Дотоод томилолтын зардал	7,200,000.00	5,324,250.00	1,875,750.00	73.9
16	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,681,321,000.00	1,387,255,197.75	294,065,802.25	82.5
17	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,681,321,000.00	1,387,255,197.75	294,065,802.25	82.5
18	Бараа үйлчилгээний бусад зардал	3,773,749,800.00	3,283,979,738.61	489,770,061.39	87.0
19	Бараа, үйлчилгээний бусад зардал	3,773,749,800.00	3,283,979,738.61	489,770,061.39	87.0
20	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ	1,290,000,000.00	1,256,614,103.18	33,385,896.82	97.4
21	Барилга байгууламж, их засвар	67,877,700.00	67,877,710.91	(10.91)	100.0
22	Тоног төхөөрөмж	1,121,713,200.00	1,119,009,119.55	2,704,080.45	99.8
23	Бусад хөрөнгө	100,409,100.00	69,727,272.72	30,681,827.28	69.4
24	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,879,775,600.00	6,217,190,606.02	662,584,993.98	90.4
25	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	9,427,014.62	-	
26	Туслах үйл ажиллагааны орлого		9,427,014.62		
27	Эх үүсвэрээс санхүүжих	6,879,775,600.00	6,207,763,591.40	672,012,008.60	90.2
28	Төсвийн урсгал санхүүжилт	564,700,000.00	442,110,154.52	122,589,845.48	
29	Зээлийн санхүүжилт	6,315,075,600.00	5,765,653,436.88	549,422,163.12	
30	Тохируулгын дүн		57,892,693.06		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,824,184,980.99		
32	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,069,795,095.25		
33	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
34	Байгууллагын тоо	1	1		
35	Ажиллагсдын тоо	8	8		
36	Удирдах ажилтан	1	1		
37	Гүйцэтгэх ажилтан	7	7		

4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/40/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Дээд боловсролын шинэчлэл төсөл			Мянган төгрөгөөр	

/мянган төгрөг/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мян,төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	3	4.0	5	8	9
1	Тайлант онд төслийн Төрийн банкинд байршиж байгаа ам долларын тусгай болон дэд дансны харилцах дансанд төвлөрүүлсэн хүүгийн орлого 39,503.9 мянган төгрөг, үүнээс төсөвт 33,071.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, 6,432.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.	6,432.6	Акт тогтоох	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан Худалдан авалтын ажилтан	Б.Мөнхзул Р.Баярмаа Ж.Жижгээ
Нийт дүн		6,432.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/86

Улаанбаатар хот

СЯГ - 00 20/40/СТА - ТХМ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төслийн Төрийн банкинд байршиж байгаа ам долларын тусгай болон дэд дансны харилцах дансанд хүүгийн орлого нийт дүнгээр 35,065,518.32 төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнээс төсөвт 28,632,923.70 төгрөгийг төвлөрүүлж, 6,432,594.62 төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "... бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Өрийн удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах", Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх" журмын 9 дүгээр зүйл, 9.1.11-д "гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол төслийн тусгай болон дэд дансны хүүгийн орлогыг захиран зарцуулах, шийдвэр гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь.

1. Хүүгийн орлого 6,432,594.62 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;

Акт, албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтныг хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kherep\Akt\2020\0325SAG11 Docx

001090251

2. Актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дээд боловсролын шинэчлэлийн төслийн нэгжийн төсвийн шууд захирагч, төслийн зохицуулагч Б.Мөнхзул, төслийн санхүүгийн ажилтан Р.Баярмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ц.Наранчимэг*
АХЛАХ АУДИТОР *Б.Сэржмядаг*
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
АУДИТОР *Н.Дэлгэрмаа*

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Н.ДЭЛГЭРМАА

0019120396

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ,
Б.Мөнхзул
Б.МӨНХЗУЛ
ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН АЖИЛТАН
Р.Баярмаа
Р.БАЯРМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

